

**НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

1. *Төлөвлөгөө*: НМХГ-ын Ёс зүйн зөвлөл нь байгууллагын албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны төлөвлөгөөг 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан.

2. *Сургалт*: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 154 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/380 дугаар захирамжаар Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан олон нийтийг хамарсан сургалт зохион байгуулахыг хориглосон тул албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх талаар сургалтыг 3 дугаар улиралд цахим хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөсөн.

3. *Сурталчилгаа*: НМХГ-ын цахим хуудсанд 2021 оны хагас жилийн байдлаар ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, ёс зүйн зөрчлийн мэдээг шинэчлэн байршуулсан.

4. *Ёс зүйн зөрчлийн талаар*: Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан хариуцлага хүлээлгэх үүрэг бүхий Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор уг зөвлөлийн ажиллах журамд тус газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/20 дугаартай тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан.

2021 оны эхний хагас жилийн байдлаар тус газрын Ёс зүйн зөвлөлд 6 улсын /ахлах/ байцаагчийн ёс зүйтэй холбогдох 4 гомдол, улсын байцаагчийн үнэмлэхээ үрэгдүүлсэн гэх 1 өргөдөл ирснийг 3 удаагийн хурлаар хэлэлцүүлсэн. Ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон 3 улсын байцаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай 2 тогтоол, улсын байцаагчийн үнэмлэхээ үрэгдүүлсэн 1 улсын байцаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай 1 тогтоол тус тус гарсан ба 2 улсын /ахлах/ байцаагчид ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдоогүй байна. /хүснэгт 1/.

Хүснэгт 1

№	Гомдол гаргасан, иргэн аж ахуйн нэгжийн нэр	Зөрчил гаргасан улсын /ахлах/ байцаагчийн нэр	Гомдлын агуулга	Шийдвэрлэсэн байдал
1	БГД дэх МХХ-ийн Ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын улсын байцаагч Т.Эрдэнэсайхан	Экспорт, Импорт хилийн хорио цээрийн хяналтын хэлтсийн дарга Н.Гэрэлт-Одын ёс зүйтэй холбоотой асуудал	...улсын байцаагчдийг удаа дараа гүтгэж, дарамталж, ажил үүргээ гүйцэтгэж явахад далд аргаар зураг авч, бичлэг хийж, ёс зүйгүй үйлдэл гаргадаг... гэх	2021 оны 02 дугаар сарын 05-ний өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1,2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, Н.Гэрэлт-Одод “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.4.б, 3.1.5.а, 3.1.7.а, 3.1.7.б дахь заалтуудыг үндэслэн ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ гаргасан

2	Хан-Уул дүүрэг дэх МХХ-ын Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Э.Отгонсүрэн, Ц.Сүглэгмаа	Хан-Уул дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга Б.Алтантуяагийн ёс зүйтэй холбоотой асуудал	“..Б.Алтантуяа нь хамт олноо удирдан зохион байгуулах чадваргүй, төрийн албан хаагч миний албаны болон хувийн нэр төр, алдар хүндэд байнга халдаж, удаа дараа хохироосон ...” гэх мөн тус дүүрэг дэх улсын байцаагч Ц.Сүглэгмаа нь өөрийн гомдолдоо “.....төрийн албаны ёс зүйд нийцэхгүй үйлдлийг гаргаж байгаа....” гэх	2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, ёс зүйн зөрчилтэй гэх нь нотлогдоогүй болно.
3	Иргэн Э.Ариунболд	СХД дэх МХХ-ийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын ахлах байцаагч А.Бат-Эрдэнийн ёс зүйтэй холбоотой асуудал	...намайг доромжилж төрийн захиргааны албан хаагчийн өрөөнөөс хөөж гаргасан ... гэх	2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, ёс зүйн зөрчилтэй гэх нь нотлогдоогүй болно.
4	Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч Л.Гэндэнжамц	Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч Л.Гэндэнжамц улсын байцаагчийн үнэмлэхээ гээгдүүлсэн тухай	... улсын байцаагчийн үнэмлэхээ гээгдүүлсэн гэх	2021 оны 03дугаар сарын 30-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.1.а дахь заалтыг үндэслэн ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ гаргасан.
5	НМХГ-ын Олон нийттэй харилцах хэлтэс	ХУД дэх МХХ-ийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын ахлах байцаагч С.Долгор, Эрүүл ахуй халдвар хамгааллын улсын байцаагч Э.Отгонсүрэн, Л.Мөнхсаруул нарын ёс зүйтэй холбоотой асуудал	Фэйсбүүк хуудсанд байрлах “Мэргэжлийн хяналтынхан” нэртэй хаалттай группд улсын байцаагч нар нь Ёс зүйн дүрэм зөрчсөн гэх	2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, С.Долгор, Э.Отгонсүрэн нарт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.1.а, 3.1.4.е дахь заалтыг тус тус үндэслэн ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ гаргасан

4. Архив, албан хэрэг хөтлөлт:

Ёс зүйн хорооны 2020 оны хурлын тэмдэглэл, дүгнэлт, үйл ажиллагаатай холбогдолтой тайланг архивын нэгж болгон хавтаслан архивын эрхлэгчид хүлээлгэн өгсөн.

5. Судалж буй өргөдөл гомдол:

1.Байхгүй.

---oOo---